


**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар АНН

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 3.2.4, Засгийн газрын 2019 оны "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 485 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны "Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/364 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам"-ыг шинэчлэн баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нарт, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганццэг), сайн дурын даатгалын програм хангамжийг даалгаврын дагуу боловсруулж 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дотор аймаг, дүүргийн хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хурэлбаатар), төлсөн шимтгэлийг бүртгэж тооцоо хийх, тайлагнах, шимтгэл төлөх үндэслэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэлийн газар (Б.Даваахүү), журмын хэрэгжилтийг нийгмийн даатгалын хэлтсүүдэд шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг цаг хугацаанд нь шуурхай шийдвэрлэж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА _____ Д.ЗОРИГ

515110003



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР
ДААТГУУЛАХАД БАРИМТЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-БХСГ -2020

Баталсан: НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  Д.ЗОРИГТ

Хянасан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА  Ц.ГАНЦЭЦЭГ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  Г.ЛХАГВАДОРЖ

Боловсруулсан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН  Ж.НАРМАНДАХ

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	

АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Сайн дурын даатгалын хамрах хүрээ, гэрээ байгуулах, бүрдүүлэх баримт бичиг
6. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах
7. Даатгуулагчийн шимтгэл төлөлт, буцаан олголт
8. Мэдээллийн санд мэдээлэл оруулах, дэвтэр баталгаажуулах
9. Гэрээний хугацааг сунгах, өөрчлөх, дуусгавар болгох, хүчингүйд тооцох, цуцлах
10. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих
11. Маргаан шийдвэрлэх, хүлээх хариуцлага



Нийгмийн даатгалын ерөнхий ерөнхий газрын
дарын 2020 оны 01 дүгээр сарын 2-ны
одрийн А/1 дүгээр тушаалын хэвсрэлт**НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛАХАД
БАРИМТЛАХ ЖУРАМ**

НЭГ. Зорилго

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 5 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйл, мөн зүйлийн 3.6 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 485 дугаар тогтоол болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/01 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ"-нд заасныг тус тус үндэслэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЕР. Хамрах хүрээ

Энэхүү журмаар нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ байгуулах, сайн дурын даатгалтай холбоотой үйлчилгээг цахимаар авах, шимтгэл төлөх, эхчүүдийн хүүхдээ 3 нас хүртэл нь асрах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх, мэдээллийн санд мэдээлэл оруулах, баталгаажуулах, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах, гэрээг дуусгавар болгох, маргаан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

ГУРАВ. Хамаарах талууд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Мэдээллийн технологийн төв, аймаг (нийслэл), дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс (газар), тасаг, сумын байцаагч, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

ТАВ. Сайн дурын даатгалын хамрах хүрээ,
гэрээ байгуулах, бүрдүүлэх баримт бичиг

5.1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт тодорхой хөдөлмөр эрхлээгүй, мөн зүйлийн 4.2-т зааснаас бусад хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувиараа тээвэр хийдэг жолооч, бичил уурхай эрхлэгч, газар тариалан эрхлэгч (ногоочин), малчин, оюутан, захиргааны цалингүй нэг ба түүнээс дээш сарын чөлөө авсан, гадаад улс оронд ажиллаж, амьдарч байгаа Монгол улсын иргэн, хүүхдээ 3 нас (2нас 11 сар 29 хоногтой) хүртэл нь асарч байгаа

эх, ажилгүй болон албан журмаар даатгуулснаас бусад иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулж болно.

5.2. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эхийг дор дурдсанаар ангилна:

5.2.1. "Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ"-ний 1.4.11-д заасан тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсэж, хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байгаа эх;

5.2.2. "Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ"-ний 1.4.12-т заасан тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй, хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байгаа эх.

5.3. Энэ журмын 5.1, 5.2-т заасан иргэний нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах хүсэлтийг нийгмийн даатгалын байцаагч хүлээн авч, түүнтэй гэрээний хугацааг тохиролцон, сар, улирал, хагас жил, жилээр байгуулна.

5.4. Гэрээний хугацааг даатгуулагчийн төлсөн шимтгэл нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд орсон өдрөөс үл хэмааран тухайн сарын 01-ний өдрөөс эхлэхээр байгуулна.

5.5. Гэрээг батлагдсан маягтын дагуу програмаас 2 хувь хэвлэн нийгмийн даатгалын байцаагч, даатгуулагч гарын үсэг зурж баталгаажуулна. Зөвшөөрсөн маягтаас өөр хэлбэрээр гэрээ байгуулахыг хориглоно.

5.6. Даатгуулагч гэрээ байгуулахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

5.6.1. Иргэний үнэмлэх;

5.6.2. Нийгмийн даатгалын дэвтэр (байхгүй бол шинээр нээлгэнэ);

5.6.3. Зураг 1% (нийгмийн даатгалын дэвтэр шинээр нээлгэх бол);

5.6.4. Энэ журмын 5.2-т заасан эхийн хувьд хүүхдийн төрсний гэрчилгээ.

ЗУРГАА. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах

6.1. Гадаад улс оронд ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулж болно.

6.2. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа даатгуулагч Нийгмийн даатгалын ерөнхий газрын <http://www.ndaatgai.mn/> цахим хуудаст байршуулсан цахим системийн нэрийг зөв оруулж, цахим системд байгаа анхааруулгатай танилцан Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай цахим гэрээ (НД № 10А)-нд заасан мэдээллийг үнэн зөв оруулж, шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлсний хэмжээ, шимтгэл төлөх хугацааг сонгож, Монгол Улсаас олгосон гадаад паспортын зурагтай нүүр хэсгийн хуулбарын хамт нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээнэ.

6.4. Даатгуулагч нь өөрийн дэлгэрэнгүй мэдээлэл, байгуулсан гэрээ, гадаад паспортын хуулбарыг өөрийн данс байршиж буй банкинд илгээхийг зөвшөөрсөн хүсэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт цахимаар ирүүлнэ.



ДОЛОО. Даатгуулагчийн шимтгэл төлөлт, буцаан олголт

7.1. Даатгуулагч нь нийгмийн даатгалын шимтгэл тооцох сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээг өөрөө мэдүүлж, нийгмийн даатгалын байгууллагатай тохиролцон гэрээнд тусгана.

7.2. Энэ журмын 5.2-т заасан даатгуулагч эх хүүхдээ 3 нас хүртэл нь асрах хугацааны сард төлбөл зохих шимтгэлийн 50%-ийг өөрөө төлсөн нөхцөлд үлдэх 50%-ийг доор дурдсанаар төлнө:

7.2.1. Даатгуулагч эх нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон шимтгэлээ төлөхөөр гэрээ байгуулсан тохиолдолд Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам"-ын 2-т заасны дагуу тэтгэврийн даатгалын санд 11,5 хувь, тэтгэмжийн даатгалын санд 1,0 хувь, нийтдээ 12,5 хувиар тооцон шимтгэлээ төлнө.

Санамж¹: Сайн дурын даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (420000 төг)-нээс тооцон төлөх даатгуулагч эх тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын санд сард төлбөл зохих шимтгэл 52500 төгрөг ($420000 \text{ төг} \cdot 12,5\%$)-ийн 50 хувь болох 26250 төгрөг ($52500 \text{ төг} \cdot 50\%$)-ийг өөрөө төлсөн нөхцөлд үлдсэн 50 хувь болох 26250 төгрөгийг энэ журмын 5.2.1-д заасан даатгуулагч бол тэтгэмжийн даатгалын сангаас, 5.2.2-т заасан даатгуулагч бол улсын төсвөөс тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд төлүүлнэ.

7.2.2. Даатгуулагч эх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос тооцон шимтгэлээ төлөхөөр гэрээ байгуулсан тохиолдолд уг орлогоос 13,5 хувь (тэтгэврийн даатгалын санд 11,5 хувь, тэтгэмжийн даатгалын санд 1,0 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан еөнчийн даатгалын санд 1,0 хувь)-иар төлөх бөгөөд тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс хариуцан төлөх шимтгэлийн хэмжээнээс илүү гарсан хэсгийг даатгуулагч эх өөрөө хариуцан төлнө.

Санамж²: Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн, хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байгаа даатгуулагч эх сард 800000 төгрөгийн орлогоос шимтгэл төлөхөөр гэрээ байгуулсан бол тухайн эх сард 81750 төгрөг ($800000 \text{ төг} \cdot 13,5\% = 108000 \text{ төг} - 26250 \text{ төг}$) төлнө. Даатгуулагч эх тэтгэврийн даатгалын санд 11,5 хувь буюу 67850 төгрөг ($800000 \text{ төг} \cdot 11,5\% = 92000 \text{ төгрөг}$ өөс тэтгэмжийн даатгалын сангаас төлөх 24150 төгрөгийг хасч), тэтгэмжийн даатгалын санд 1,0 хувь буюу 5900 төгрөг ($800000 \text{ төг} \cdot 1\% = 8000 \text{ төгрөг}$ өөс тэтгэмжийн даатгалын сангаас төлөх 2100 төгрөгийг хасч), үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан еөнчийн даатгалын санд 1,0 хувь буюу 8000 төгрөг ($800000 \text{ төг} \cdot 1,0\% = 8000 \text{ төгрөг}$, үүнээс тэтгэмжийн даатгалын сангаас төлөхгүй)-ийн шимтгэлийг өөрөө төлсөн нөхцөлд тэтгэмжийн даатгалын сангаас 26250 төгрөг төлүүлж, тэтгэврийн даатгалын санд 11,5 хувиар буюу 24150 төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 1,0 хувиар буюу 2100 төгрөгийн ногдуулалт хийнэ;



Санамж²: Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй, хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байгаа даатгуулагч эх сард 700000 төгрөгийн орлогоос шимтгэл төлөхөөр гэрээ байгуулсан бол тухайн эх сард 68250 төгрөг (700000 төг*13,5%=94500 төг-26250 төг) төлнө. Даатгуулагч эх тэтгэврийн даатгалын санд 11,5 хувь буюу 56350 төгрөг (700000 төг*11,5%=80500 төгрөгөөс улсын төсвөөс төлөх 24150 төгрөгийг хасч), тэтгэмжийн даатгалын санд 1,0 хувь буюу 4900 төгрөг (700000 төг*1%=7000 төгрөгөөс улсын төсвөөс төлөх 2100 төгрөгийг хасч), үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 1,0 хувь буюу 7000 төг (700000 төг *1,0%=7000 төгрөг, үүнээс улсын төсвөөс төлөхгүй)-ийн шимтгэлийг өөрөө төлсөн нөхцөлд улсын төсвөөс 26250 төгрөг төлүүлж, тэтгэврийн даатгалын санд 11,5 хувиар буюу 24150 төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 1,0 хувиар буюу 2100 төгрөгийн ногдуулалт хийнэ.

7.3. Даатгуулагч шимтгэлээ банкны салбараар эсхүл цахим хэлбэрээр, болон бусаар төлнө.

7.4. Даатгуулагч шимтгэлээ гэрээгээр тохирсон хугацаанд төлөх үүрэгтэй.

7.5. Даатгуулагч шимтгэлээ гэрээгээр тохирсон хугацаандаа төлөөгүй, эсхүл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээнд заасны дагуу алданги тооцож, хариуцлага хүлээлгэнэ.

7.6. Сайн дурын даатгалын гэрээний хугацаанд албан журмын даатгалд хамрагдан давхар шимтгэл төлсөн тохиолдолд даатгуулагчийн сайн дурын даатгалд төлсөн шимтгэлийг буцаан олгоно.

7.6.1. Даатгуулагч эхийн албан журмын болон сайн дурын даатгал тухайн сард давхардсан тохиолдолд даатгуулагчийн сайн дурын даатгалд төлсөн шимтгэлийг буцаан олгож, тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан төлсөн шимтгэлийг холбогдох санд буцаан шилжүүлнэ.

НАЙМ. Мэдээллийн санд мэдээлэл оруулах, дэвтэр баталгаажуулах

8.1. Нийгмийн даатгалын байцаагч нь даатгуулагч (иргэн)-ийг даатгуулах хүсэлтээ гарган эхний сарын шимтгэлээ төлсөн тохиолдолд нийгмийн даатгалд даатгуулсан тухай гэрээг байгуулж, мэдээллийн санд холбогдох мэдээллийг үнэн зөв оруулна.

8.2. Даатгуулагч жил бүр нийгмийн даатгалын дэвтэрт нийгмийн даатгалын байцаагчаар бичилт хийлгэж, тооцоо хийнэ.

8.3. Даатгуулагч эхийн өөрөө төлсөн болон тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс төлсөн шимтгэлийг нэгтгэн, нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулалт хийнэ.

ЕС. Гэрээний хугацааг сунгах, өөрчлөх, дуусгаар болгох,
хүчингүйд тооцох, цуцлах

9.1. Даатгуулагч гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээ сунгах хүсэлтээ өөрийн биеэр эсвэл цахимаар мэдэгдэн гэрээний хугацааг сунгаж болно.



9.1.1. Даатгуулагч гэрээний хугацаа дууссаны дараагийн сард багтаан гэрээг сунгах хүсэлт гарган, шимтгэлээ төлсөн тохиолдолд гэрээний хугацааг өмнө байгуулсан хугацаагаар үргэлжлүүлэн сунгасанд тооцно.

9.1.2. Харин энэ журмын 9.1.1-д заасан хугацаанд шимтгэлээ төлөөгүй тохиолдолд шимтгэл төлөгдсөн сарын 1-ний өдрөөс эхлэн даатгуулагчийн өмнө байгуулсан хугацаагаар гэрээг сунгасанд тооцно.

9.1.3. Гэрээний хугацаа сунгагдсан тэмдэглэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/01 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын сайн дураар даатгуулсан тухай гэрээ"-ний хавсралт хэсэгт хийнэ.

9.1.4. Гэрээний хугацааг цахимаар сунгасан тохиолдолд даатгуулагчийг нийгмийн даатгалын дэвтэрт баталгаажуулалт хийлгэхээр ирэх үед гэрээг 1 хувь хэвлэн 2 талаас гарын үсэг зурж баталгаажуулан Нийгмийн даатгалын хэлтэст хадгална.

9.2. Гэрээний хугацаанд даатгуулагчийн шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлсний хэмжээг өөрчлөхгүй. Харин дараах 2 нөхцөлд энэ журмын 9.1.3-т заасан хавсралтад өөрчлөлт оруулж болно. Үүнд:

9.2.1. Хууль болон Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорсоны шийдвэрээр шимтгэлийн хувь хэмжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлтийн хэмжээгээр;

9.2.2. Шимтгэл ногдуулах орлогоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байхаар мэдүүлсэн даатгуулагч зөвхөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөх үед өөрөө хүсвэл шимтгэл ногдуулах орлогоо нэмэгдүүлэн өөрчлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд.

9.2.3. Даатгуулагч эх хүүхдээ төрүүлэхээс өмнө сайн дурын даатгалын гэрээтэй байсан тохиолдолд гэрээг энэ журмын 5.2-т заасан ангиллаар шинэчлэн байгуулна.

9.3. Даатгуулагчийн гэрээний хугацаа дараах тохиолдолд дуусгавар болно.

9.3.1. Аж ахуйн нэгж, байгууллагад ажилд орсон;

9.3.2. Иргэний харьяалал шилжсэн даатгуулагч хүсэлт гаргасан;

9.3.3. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон;

9.3.4. Нас барсан;

9.3.5. Даатгуулагч эхийн хүүхэд нь 3 насанд хүрсэн.

9.4. Гэрээг дараах тохиолдолд хүчингүйд тооцно. Үүнд:

9.4.1. Шимтгэл төлж гэрээ байгуулснаас өмнөх саруудын шимтгэлийг нөхөн төлсөн;

9.4.2. Гэрээг хуурамчаар үйлдсэн;



